



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

“Кловер ББСБ” ХХК-д
банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх
тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдан, 2013 оны 532 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Кловер ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, холбогдох өөрчлөлтийн тэмдэглэгээг тусгай зөвшөөрлийн болон Улсын бүртгэлийн гэрчилгээнд хийлгэж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн баримт бичгийг 2015 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Кловер ББСБ” ХХК /Д.Итгэлмаа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000549